



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2023/163/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 17</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	20
5.3. Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № *2/67*

танай _____ -ны № _____ -т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Г **БАЯНХОНГОР АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
НОМУНДАЛАЙ ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ц.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллага нь багш, ажиллагсдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо холбогдох тушаал, журмыг баримтлалгүй 2022 оны 12 сард багш нарт 10-25 хувиар 3 сар, ажиллагсдад 25 хувиар 6 сараар бодож 78.5 сая төгрөг олгосон байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

• 005020301

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургууль нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98.6 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургууль нь 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	240,780,067.83	301,095,364.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	38,185,578.02
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	38,185,578.02
3121	Төгрөг	00.00	38,185,578.02
31211	Төрийн сангийн харилцах	00.00	38,185,578.02
33	АВЛАГА	1,132,783.57	1,506,625.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	25,460.55	145,540.56
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,000,000.00	1,000,000.00
335	Бусад авлага	107,323.02	361,085.20
3351	Байгууллагаас авах авлага	107,323.02	361,085.20
34	УРЬДЧИЛГАА	2,748.00	2,748.00
3471	Урьдчилгаа тооцоо	2,748.00	2,748.00
34713	Цалингийн урьдчилгаа	2,748.00	2,748.00
35	БАРАА МАТЕРИАЛ	239,644,536.26	261,400,413.21
351	Түүхий эд материал	15,451,098.00	5,525,700.00
35130	Эм боох материал	15,451,098.00	5,525,700.00
354	Хангамжийн материал	218,719,438.26	255,874,713.21
35410	Бичиг хэргийн материал	1,655,000.00	5,588,000.00
35420	Аж ахуйн материал	16,109,692.49	9,461,312.00
35440	Түлш, шатах тослох материал	853,383.28	00.00
35450	Барилгын засварын материал	9,666,762.01	5,954,540.21
35470	Бусад хангамжийн материал	190,434,600.48	234,870,861.00
35600	Мал амьтад	5,474,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,845,944,720.19	10,566,749,717.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,845,944,720.19	10,566,749,717.34
392	Биет хөрөнгө	9,953,941,053.45	9,677,634,050.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,105,692,267.00	9,695,591,267.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-552,915,392.78	-575,116,249.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	584,501,689.81	821,127,392.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-413,606,416.24	-467,109,973.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	375,158,446.32	376,958,446.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-183,990,148.86	-212,977,440.66
39217	Ном	39,100,608.20	39,160,608.20
393	Биет бус хөрөнгө	892,003,666.74	889,115,666.82
39301	Програм хангамж	13,715,000.00	13,715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,006,333.26	-5,894,333.18
39303	Бусад биет бус хөрөнгө	881,295,000.00	881,295,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,086,724,788.02	10,867,845,082.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,716,409.26	2,640,652.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,716,409.26	2,640,652.67
413	Өглөг	1,716,409.26	2,640,652.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.30	1,214,762.87
41320	Бараа үйлчилгээний зардын өглөг	1,576,796.96	1,425,889.80
4136	Бусад өглөг	139,612.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	139,612.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,085,008,378.76	10,865,204,429.66
51	Засгийн газрын хувь оролцоо	11,085,008,378.76	10,865,204,429.66

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,483,997,027.68	2,483,997,027.68
51101	Өмч: - төрийн	2,483,997,027.68	2,483,997,027.68
512	Хуримтлагдсан үр дүн	7,000,826,639.52	7,191,123,690.42
51210	Өмнөх үеийн үр дүн	7,000,826,639.52	7,410,927,639.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-219,803,949.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,600,184,711.56	1,190,083,711.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,086,724,788.02	10,867,845,082.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,912,603,910.38	5,563,070,096.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,686,373,774.38	233,298,896.42
120	Нийтлэг татварын бус орлого	8,686,373,774.38	233,298,896.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,000,000.00	76,122,999.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	75,982,999.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	902,505,036.00	5,329,771,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,323,725,100.00	4,349,982,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	4,349,982,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,323,725,100.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,528,744.00	50,578,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,382,353.00	50,578,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,146,391.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	718,976,292.00	929,210,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	718,976,292.00	929,210,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,401,751,448.56	5,600,894,204.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,401,751,448.56	5,600,894,204.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,212,651,185.05	5,304,474,066.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,698,766,065.00	3,468,104,641.87
210101	Үндсэн цалин	2,698,766,065.00	1,889,193,758.00
210102	Нэмэгдэл	00.00	1,383,575,066.87
210104	Урамшуулал	00.00	82,414,617.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	112,921,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	349,135,495.82	432,878,126.12
210201	Тэтгэврийн даатгал	244,803,571.37	294,706,152.78
210202	Тэтгэмжийн даатгал	26,955,530.45	36,796,100.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,574,500.00	25,931,173.69
210204	Ажилгүйдлийн даатгал	5,062,209.00	8,366,041.31
210205	Эрүүл мэндийн даатгал	50,739,685.00	67,078,658.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	699,843,088.96	787,340,725.86
210301	Гэрэл, цахилгаан	24,304,146.96	53,118,329.86
210302	Түлш, халаалт	600,913,150.00	640,974,112.00
210303	Цэвэр, бохир ус	74,625,792.00	93,248,284.00

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	36,669,528.40	41,343,199.14
210401	Бичиг хэрэг	7,922,450.00	13,251,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,010,327.10	2,116,243.28
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,385,739.50	2,702,835.37
210404	Ном, хэвлэл	1,215,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,398,000.00	48,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,738,011.80	23,223,620.49
2105	Нормативт зардал	36,495,895.80	85,011,013.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,641,060.00	10,787,628.00
210502	Хоол, хүнс	30,509,370.00	74,223,385.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,345,465.80	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,017,584.99	18,952,021.80
210604	Урсгал засвар	46,017,584.99	18,952,021.80
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,390,850.00	24,025,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,790,850.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	24,025,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	324,260,676.08	446,819,338.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,965,000.00	49,638,274.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,981,500.00	61,480,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	297,314,176.08	335,700,864.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	189,100,263.51	296,420,137.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,141,675.00	296,419,346.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,022,850.00	246,340,646.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,382,353.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	50,078,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,736,472.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	791.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	791.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,958,588.51	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,958,588.51	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,510,852,461.82	-37,824,108.01
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,000.00	181,979,841.09
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,000.00	181,979,841.09
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-50,000.00	-181,979,841.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,510,802,461.82	-219,803,949.10

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,237,130,136.00	5,409,537,199.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,046,391.00	79,765,999.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,046,391.00	79,765,999.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,046,391.00	79,765,999.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,196,391.00	75,982,999.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,000.00	3,783,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,171,083,745.00	5,329,771,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,323,725,100.00	4,349,982,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,323,725,100.00	4,349,982,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128,382,353.00	50,578,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,382,353.00	50,578,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	718,976,292.00	929,210,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	718,976,292.00	929,210,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,130,434,002.50	5,256,282,620.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,130,434,002.50	5,256,282,620.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,944,776,503.99	4,960,276,326.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,690,635,636.99	3,467,901,328.32
210101	Үндсэн цалин	1,723,049,992.00	1,994,118,850.52
210102	Нэмэгдэл	818,645,964.99	1,278,446,660.80
210104	Урамшуулал	148,939,680.00	82,414,617.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	112,921,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	354,601,400.00	432,310,369.11
210201	Тэтгэврийн даатгал	262,579,300.00	296,419,999.40
210202	Тэтгэмжийн даатгал	22,694,700.00	34,395,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,383,100.00	27,516,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,626,100.00	6,878,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	46,318,200.00	67,099,569.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	697,976,292.00	789,173,108.02
210301	Гэрэл, цахилгаан	22,437,400.00	54,950,712.02
210302	Түлш, халаалт	600,913,100.00	640,974,112.00
210303	Цэвэр, бохир ус	74,625,792.00	93,248,284.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,602,700.00	00.00
210401	Бичиг хэрэг	3,627,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,049,200.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	2,028,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,398,000.00	00.00
2105	Нормативт зардал	58,253,093.00	73,275,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,480,208.00	00.00

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	33,901,365.00	73,275,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,871,520.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,204,672.00	13,000,000.00
210604	Урсгал засвар	46,204,672.00	13,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,845,200.00	33,815,466.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,005,200.00	4,283,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	29,532,466.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,585,510.00	150,800,853.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,830,000.00	87,709,553.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,755,510.00	63,091,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,657,498.51	296,006,294.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	182,698,910.00	296,005,502.98
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,652,975.00	245,926,802.98
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	128,382,353.00	50,078,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,663,582.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	791.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	791.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,958,588.51	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,958,588.51	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>106,696,133.50</u>	<u>153,254,578.02</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>90,613,491.00</u>	<u>115,069,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>90,613,491.00</u>	<u>115,069,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>90,613,491.00</u>	<u>115,069,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	90,613,491.00	115,069,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-90,613,491.00</u>	<u>-115,069,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,082,642.50	38,185,578.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	38,185,578.02

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,264,054,795.77	1,121,541,355.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,264,054,795.77	1,121,541,355.91
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-143,044,864.93	-143,044,864.93
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	7,000,826,639.52	11,085,008,378.76
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	7,000,826,639.52	11,085,008,378.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	410,101,000.00	410,101,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	7,410,927,639.52	11,495,109,378.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-410,101,000.00	00.00	-410,101,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-219,803,949.10	-219,803,949.10
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,190,083,711.56	7,191,123,690.42	10,865,204,429.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,375,384,300.00	5,320,772,920.98	54,611,379.0	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,375,384,300.00	5,320,772,920.98	54,611,379.0	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,116,476,100.00	7,074,845,326.02	1,958,369,226.0	138.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,482,600,700.00	3,467,901,328.32	14,699,371.7	99.6
210101	Үндсэн цалин	2,578,271,000.00	1,994,118,850.52	584,152,149.5	77.3
210102	Нэмэгдэл	730,773,700.00	1,278,446,660.80	-547,672,960.8	174.9
210104	Урамшуулал	60,634,800.00	82,414,617.00	-21,779,817.0	135.9
210105	Гэрээт ажлын хөлс	112,921,200.00	112,921,200.00	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	435,791,300.00	432,310,369.11	3,480,930.9	99.2
210201	Тэтгэврийн даатгал	296,607,200.00	296,419,999.40	187,200.6	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	34,796,200.00	34,395,700.00	400,500.0	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,836,700.00	27,516,300.00	320,400.0	98.8

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	6,959,100.00	6,878,800.00	80,300.0	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	69,592,100.00	67,099,569.71	2,492,530.3	96.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	789,173,900.00	789,173,108.02	792.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	54,973,500.00	54,950,712.02	22,788.0	100.0
210302	Түлш, халаалт	640,974,100.00	640,974,112.00	-12.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	93,226,300.00	93,248,284.00	-21,984.0	100.0
2105	Нормативт зардал	73,275,200.00	73,275,200.00	0.0	100.0
210502	Хоол, хүнс	73,275,200.00	73,275,200.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00	13,000,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	13,000,000.00	13,000,000.00	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,201,900.00	33,315,466.70	12,886,433.3	72.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,668,800.00	3,783,000.00	12,885,800.0	22.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,533,100.00	29,532,466.70	633.3	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	276433100.00	265869853.87	10,563,246.1	96.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	213,341,800.00	202,778,553.87	10,563,246.1	95.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,091,300.00	63,091,300.00	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258908200.00	245926802.98	12,981,397.0	95.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	258,908,200.00	245,926,802.98	12,981,397.0	95.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	258,908,200.00	245,926,802.98	12,981,397.0	95.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,375,384,300.00	5,358,957,707.02	16,426,593.0	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,349,982,200.00	4,349,982,200.00	0.0	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,349,982,200.00	4,349,982,200.00	0.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	929,210,300.00	929,209,508.02	792.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	929,210,300.00	929,209,508.02	792.0	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,191,800.00	79,765,999.00	16,425,801.0	82.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,523,000.00	75,982,999.00	3,540,001.0	95.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,668,800.00	3,783,000.00	12,885,800.0	22.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	170	170	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	124	124	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	45	45	0.0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	2,378	2,378	0.0	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	2,378	2,378	0.0	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	2,378	2,378	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,578,744.00	50,578,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,578,744.00	50,578,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,196,391.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,196,391.00	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,196,391.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,382,353.00	50,078,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,382,353.00	50,078,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,382,353.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		50,078,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	183,578,744.00	50,578,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,578,744.00	50,578,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1840491.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,382,353.00	50,578,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	53,355,900.00	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор нь “Сурагч бүрийн сурлагын чанарт ахиц гарган, хүүхдийн эрхийг дээдэлж,багийн үйл ажиллагааг эрхэмлэсэн сургалт төлөвшил хөгжлийн төв бүхий сургууль байна” гэсэн эрхэм зорилгын хүрээнд тайлант онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх сонгон дугуйлан хичээллүүлэх
- Багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хөгжих бололцоогоор хангах
- Эцэг эх олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Багш нарын шилдэг туршлага,сургалтын тэргүүний арга зүй технологийг түгээн дэлгэрүүлэх сурталчлах,
- Хүүхдийн өөрийн оролцооны байгууллагыг удирдах.

2022-2023 оны хичээлийн жилд өдрөөр 2,378 хүүхэд, 250 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд 115 хүүхэд хүлээн авч, ЕБС-ийн 1-5 ангийн 1100 хүүхэд үдийн цай хөтөлбөрт хамрагдсан байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг, БШУЯ-ны дотоод аудит хэрэгжүүлдэг бөгөөд Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 10,867,845.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 218,879.7 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	38,185.6	38,185.6
Авлага	1,135.5	1,509.4	373.8
Бараа материал	239,644.5	261,400.4	21,755.9
Үндсэн хөрөнгө	11,999,463.0	11,827,847.7	(171,615.3)
Хуримтлагдсан элэгдэл	(1,153,518.3)	(1,261,098.0)	(107,579.7)
Нийт хөрөнгө	11,086,724.8	10,867,845.1	(218,879.7)
Өр төлбөр	1,716.4	2,640.7	924.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,085,008.4	10,865,204.4	(219,803.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,086,724.8	10,867,845.1	(218,879.7)

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд үлдэгдэлгүй байсан бөгөөд тайлант оны эцэст улсын төсвийн санхүүжилтийн үлдэгдэл 38,185.6 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 1,509.4 мянган төгрөг болж 373.8 мянган төгрөгөөр өссөн нь гэрэл цахилгааны авлага 255.6 мянга, НДШ-ийн авлага 145,5 мянга, зургийн төсвийн 1,108.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 261,400.4 мянган төгрөг болж өмнөх оноос 21,755.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 454,991.8 мянга, Хот тохижилт ОНӨААН-ээс замын хавтан 3,181.4 мянга, түрээс сурах бичиг 14,322.7 мянган төгрөгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, 466,955.1 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Үүнээс бичиг хэргийн материал 3,933.0 мянга, бусад хангамжийн материал 44,436.3 мянган төгрөгөөр өссөн голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,827,847.7 мянган төгрөг болж 171,615.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 115,069.0 мянга, БШУЯ-аас 119,230.7 мянга, НҮБ-ийн хүүхдийн ивээх сангаас 2,386.0 мянга, хөл бөмбөгийн холбооноос 1,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, Аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн 9/28 дугаар тогтоолоор 392,167.3 мянга, 2022.09.16-ны өдрийн 10/46 дугаар тогтоолоор 17,933.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,865.2 мянган төгрөг болж 219,803.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 219,803.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,166,608.6 мянган төгрөгийг авч зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,848,333.0 мянган төгрөгөөр бууруулж 4,318,275.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 5,375,384.3 мянган төгрөг болгож 1,057,108.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81801, 81806, 81816, 81823, 81834, 81835, 81848, 81844, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,375,384.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,446,174.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 929,210.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,446,174.0 мянга, орон нутгийн төсвөөс 929,210.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй орон нутгийн төсвийн санхүүжилтээс 0.8 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,375,384.3 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 54,612.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	5,375,384.3	5,320,772.1	54,612.2	99.0
2	80226 Байр ашиглалтын зардал	11,813.2	11,808.9	4.3	100.0
3	80312 Сургалт семинарын зардал	5,906.6	5,802.8	103.8	98.2
4	81605 Эрүүл мэндийг дэмжих зардал	13,585.2	3,719.2	9,866.0	27.4
5	81801 Үдийн цай хөтөлбөр	258,908.2	245,926.8	12,981.4	95.0
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	105,847.3	105,388.1	459.2	99.6
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	115,385.0	115,069.0	316.0	99.7
8	81823 Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	26,579.8	26,356.3	223.5	99.2
9	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	3,573,313.4	3,565,850.6	7,462.8	99.8
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	238,643.5	231,968.5	6,675.0	97.2
11	81848 Сурах бичгийн түрээсийн зардал	16,668.8	3,783.0	12,885.8	22.7
12	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	79,523.0	75,889.3	3,633.7	95.4
13	80112 Нийтлэг үйлчилгээ	929,210.3	929,209.5	0.8	100.0
	Нийт дүн	5,375,384.3	5,320,772.1	54,612.2	99.0

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй ба нийт 50,578.7 мянган төгрөгийг ирснийг зориулалтын дагуу зарцуулсан.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

/мян.төг/

д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,078.7
2	Төсөл	500.0
	Нийт орлогын дүн	50,578.7
1	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,078.7
2	Бусад бараа үйлчилгээний зардал	500.0
	Нийт зарлагын дүн	50,578.7

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн 49 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн захирал Ц.Алтангэрэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 5,375,384.3 мянган төгрөгөөс тооцоход 80,630.7 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 56,441.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 133 мэдээлэл хугацаандаа оруулж 11 мэдээлэл хугацаа хоцроож 5 мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 73 мэдээллийн 5,381,016.3 мянган төгрөг мэдээлэхээс 5 мэдээллийн 40,132.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээллийн 129,302.3 мянган төгрөгийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 63 мэдээллийн 1,226,871.3 мянган төгрөгийн мэдээллээс 5 мэдээллийн 40,132.6 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 2 мэдээллийн 39,197.4 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	3	2		2
2	Хагас жил	4	4	4	0		
3	Улирал бүр	1	4	2	1	1	
4	Сар бүр	3	36	30	6		
5	Тухай бүр	8	96	94	2		
	Нийт	27	151	133	11	5	2

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, тендерийн худалдан ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Засварын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 21,851.5 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 732.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх 21,819.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2022.05.27-ны өдрийн 155 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	732.0	1	732.0	100
Албан шаардлага	1	0	1	0	100
Зөвлөмж	1	21,819.5	1	21,819.5	100
Нийт дүн	3	21,851.5	3	21,851.5	100

Эх сурвалж: 2021 оны аудитын тайлангаас

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар Үдийн цай хөтөлбөрийн зардал 12,981.4 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 79,385.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,003.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 78,51.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчил давтан гаргахгүй 330.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Эрүүл мэндийн үзлэг оношилгооны зардалд тайлант онд 3719.2 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 2022 оны 12 сард 9 ажиллагсад тус бүр 30.0 мянган төгрөгийг ажилтан, албан хаагчдын данс руу шилжүүлсэн байна.

Энэ нь БШУС-ын 2022.07.22-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ЕБС-ын багшийг эрүүл мэндийн нэмэлт, үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ын 2.8.3-т "Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг хувь хүнд олгохгүй бөгөөд багшийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийхээр гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагад үйлчилгээний төлбөрт зориулан шилжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн үзлэгийн 270.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Эрүүл мэндийн үйлчилгээний зардлаас 2022.10.20-д ЭСАМЗ-д ХХК-д 206.0 мянга, Монос Баянхонгор ХХК-д 243.2 мянган төгрөгийн эм тарианы үнэ шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн 2022 оны 91 дүгээр тогтоолын Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлалын хавсралтаар батлагдсан "ЕБС, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-ын Эрүүл мэндийн үйлчилгээний зардалд "Эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан шийдвэрийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арьс өнгө, сүрьеэ, цагаан хорхой, нян тээгч илрүүлэх үзлэг шинжилгээ, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах "Багш" багцын үзлэг, шинжилгээ багтана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан эмийн зардлын 449.2 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Дотуур байрны хүүхдийн хүнсний материалын 2023 оны 10 сарын зарлагыг хүүхдийн хоолны зарлагын менютай тулган шалгахад нярав 284.6 мянган төгрөгийг илүү зарлага гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү зарлага гаргасан 284.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн захирлын 2022.12.19-ны өдрийн Б/133 дугаар тушаалаар багш нарт 3 сар 10-25 хувь, Ажилчдад 6 сар 25 хувийн нэмэгдэлд нийт 78,051.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ЕБС-ийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийн 6-т "Багш ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж нэмэгдлийг сар бүр олгоно", 8-т "Багш ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухай байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн, холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ", 10-т "Энэхүү баримт бичгийн 4.5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц, дэвшил, амжилтын түвшнийг харгалзан, дараах хувиар тогтооно", Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 7-т "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгссөн зөвлөмж: Цаашид багш, ажиллагсдад ур чадварын нэмэгдлийг олгоходоо холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.3. Зөвлөмж

Багшийн хөгжлийн зардлаас 2022.05.13-д хөнгөн атлетикийн тэмцээн, газарзүй, орос хэлний олимпиадад оролцсон 3 багшид нийт 330,0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.12-ны өдрийн А/170 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт түүнийг зарцуулах заавар"-ын 5.2.3-т "Аливаа олимпиад, уралдаан тэмцээнд оролцох зардал"-ыг санхүүжүүлэхгүй гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Багшийн хөгжлийн зардлыг цаашид зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрүүл мэндийн үзлэг оношилгооны төлбөрт 12 сард 9 ажиллагсдад тус бүр 30.0 мянган төгрөгийг ажилтан, албан хаагчдын данс руу шилжүүлсэн байна.	1	270.0	1	270.0								
Эрүүл мэндийн үйлчилгээний зардлаас 2022.10.20-д ЭСАМЗ-д ХХК-д 206.0 мянга, Монос Баянхонгор ХХК-д 243.2 мянган төгрөгийн эм тарианы үнэ шилжүүлсэн байна.	1	449.2	1	449.2								
Багшийн хөгжлийн зардлаас олимпиадын томилолтын зардалд 330.0 мянган төгрөг олгосон байна.	1	330.0					1	330.0				
Нярав 284.6 мянган төгрөгийн илүү зарлага гаргасан байна.	1	284.6	1	284.6								
Сургуулийн захирлын тушаалаар 2022 оны 12 сард багш нарт 3 сар 10-25 хувь, ажиллагсдад 6 сар 25 хувийн нэмэгдлийг олгосон байна.	1	78,051.2			1	78,051.2						
Дүн	4	79,385.0	3	1,003,8	1	78,051.2	1	330.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 мэдээллийн 40,132.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээллийн 129,302.3 мянган төгрөгийг мэдээлээгүй, 5 мэдээллийн 40,132.6 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 2 мэдээллийн 39,197.4 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.	1	0	0	0	0	0	1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0

ooOoo